



**МОНГОЛ УЛСЫН  
ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН  
СУУЦЖУУЛАЛТЫН САЙД**

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 3, 4  
дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170  
Утас: 310612, 76003333, Факс: (976-11)-322904  
Цахим шуудан: info@mudch.gov.mn  
Цахим хуудас: www.mudch.gov.mn

2025.04.07 № 01/1178

танай 2025.03.11 -ны № 11 -т

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Ж.ГАЛБАДРАХ ТАНАА**

**Мэдээлэл хүргүүлэх тухай**

Таны 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 11 дугаартай асуулттай танилцлаа.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 114 дүгээр захирамжийн дагуу Боловсролын ерөнхий хуулийн хэрэгжилттэй танилцах, бүх шатны сургуулийн багшийн хомсдолыг бууруулах, үнэлэмжийг дээшлүүлэх болон төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн менежментийг сайжруулах асуудлыг судалж, санал, дүгнэлт гаргах ажлын хүрээнд шаардлагатай мэдээллийг гаргаж хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: 3 хуудастай.



Хот байгуулалт, барилга, орон  
сууцжуулалтын яам  
Яамны удирдлага  
Сайд  
Жамба Батсуурь  
2025-04-07 08:51:33

**Ипотекийн хөтөлбөрт хамрагдсан боловсролын салбарт ажиллагсдын мэдээлэл:**

Ипотекийн зээлийн нэгдсэн санд ЕБС болон цэцэрлэгийн багш гэсэн тусгай ангилал байдаггүй тул боловсролын салбарт хамаарах зээлдэгчдийн мэдээллийг бэлтгэн хүргүүлж байна.

Орон сууцны ипотекийн зээл авсан иргэдийн тоо ба тэдгээрээс боловсролын салбарт харъяалагдах иргэдийн тоо:

	<b>Зээлийн тоо</b>	<b>Нийт дансдад эзлэх хувь</b>
<b>Нийт</b>	<b>120,503</b>	<b>100.00%</b>
Төрийн албан хаагч	38,062	31.59%
<b>Боловсролын салбар</b>	<b>12,375</b>	<b>10.27%</b>

Боловсролын салбарт харъяалагдах зээлдэгчдийн тоо, сүүлийн 10 жилд:

<b>Зээл олгосон жил</b>	<b>Зээлийн тоо</b>	<b>Нийт дансдад эзлэх хувь</b>
<= 2015	6,606	53.38%
2016	903	7.30%
2017	566	4.57%
2018	401	3.24%
2019	484	3.91%
2020	575	4.65%
2021	1,205	9.74%
2022	706	5.71%
2023	617	4.99%
2024	312	2.52%
<b>Боловсролын салбар</b>	<b>12,375</b>	<b>100.00%</b>

Дундаж нас; хүйс:

<b>Дундаж нас</b>	40.9	
<b>Хүйс</b>	<b>Зээлийн тоо</b>	<b>Нийт дансдад эзлэх хувь</b>
<b>Эр</b>	<b>4,172</b>	<b>33.71%</b>
<b>Эм</b>	<b>8,203</b>	<b>66.29%</b>
<b>Нийт</b>	<b>12,375</b>	<b>100.00%</b>

Барьцаа хөрөнгийн хэмжээ:

<b>Барьцаа хөрөнгө /сая.төг/</b>	<b>644,920</b>
Барьцаа хөрөнгийн тоо	12,375
Үүнээс: Улаанбаатар	8,039
Үүнээс: Орон нутаг	4,336

Сарын тэнцүү төлөлт:

Ж.Д. Сарын тэнцүү төлбөр: 494,057

Сарын тэнцүү төлөлт (төгрөг)	Зээлийн тоо	Нийт дансдад эзлэх хувь
≤ 200,000	643	5.20%
200,000 < СТТ ≤ 400,000	4,609	37.24%
400,000 < СТТ ≤ 600,000	4,029	32.56%
600,000 < СТТ ≤ 800,000	1,746	14.11%
800,000 < СТТ ≤ 1,000,000	743	6.00%
1,000,000 < СТТ ≤ 1,200,000	346	2.80%
1,200,000 < СТТ ≤ 1,400,000	155	1.25%
1,400,000 < СТТ ≤ 1,600,000	54	0.44%
>1,600,000	50	0.40%
<b>Нийт</b>	<b>12,375</b>	<b>100.00%</b>

Зээлдэгчийн мэргэжлээрээ ажилласан жилийн мэдээлэл манай санд бүртгэгддэггүй болно.

**Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа хангах зорилгоор тус яамнаас хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний талаар:**

**1. Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр**

Тус яамнаас боловсролын байгууллагад ажиллагсдын нийгмийн баталгааг хангах талаар тусгайлсан бодлого хэрэгжүүлээгүй бөгөөд Монгол Улсын Алсын хараа 2050 урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан нийслэл хотын бөөгнөрлийг сааруулах, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Иргэдийн орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 483 дугаар тогтоолоор орон сууцжуулалтын талаар 5 багц ажлыг төрөөс хэрэгжүүлэхээр тогтсон. Энэ 5 багц ажлын “Миний сонголт төрийн алба” болон “Миний сонголт орон нутаг” багц ажлын хүрээнд, “Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр”-ийг 2024 оноос хэрэгжүүлж эхэлсэн.

Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөрийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

- 1-р үе шат нь 2024-2028 онд 90 тэрбум төгрөгийн улсын төсвийн санхүүжилтээр 78 байршилд хэрэгжүүлэхээр төлөвлөгдөж 2025 оны улсын төсөвт 20 тэрбум төгрөг суусан. Төсөл хэрэгжих сумдын жагсаалтыг “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д тулгуурлан инженерийн дэд бүтэц, ерөнхий төлөвлөгөөний бэлэн байдал, нийгмийн эрэлт хэрэгцээнд үндэслэн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 21 дугаар тушаалаар баталсан.

Батлагдсан жагсаалтад багтсан сумдаас Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд Орон нутгийн хөгжлийн төвөөр тодорхойлогдсон сумын төвд 15 айл, орон нутгийн хөгжлийн төвд таталцах сумдын төвд 8 айлын орон сууц төлөвлөж, нийт 804 айлын орон сууцны төсөл хэрэгжүүлнэ.

Тус төслийг хэрэгжүүлэх 2025/02 дугаартай нэгдсэн ажлын даалгаврыг Хот

байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдөр баталсан. Төсөл хэрэгжүүлэх 19 аймаг, нийслэлийн алслагдсан 2 дүүрэгт гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороодыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулагдан ажиллаж Говь-Алтай, Баян-Өлгий, Ховд, Баянхонгор аймгуудад хэрэгжих "Төрийн албан хаагчдын орон сууц" төслийн гүйцэтгэгчийг шалгаруулах тендер зарлагдсан.

- 2-р шат нь Монгол Улсын Их Хурлын 2023 оны 93 дугаар "Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1 дэх хэсгийн 1, 6 дах заалтууд, 2 дох хэсгийн 1 дэх заалт, Засгийн Газрын 2023 оны 483 дугаар "Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1.5 дах заалтын хэрэгжилтийг ханган Улаанбаатар хотын алслагдсан Багануур, Багахангай дүүрэг болон нийслэлээс бусад аймгуудад ажиллаж байгаа, өөрийн нэр дээр орон сууцгүй, анх удаа орон сууц худалдан авч байгаа төрийн албан хаагчдад ипотекийн зээлийн хүүгийн татаас олгох хугацааг төрд ажилласан жилээс хамааран сунгах талаар судлан холбогдох байгууллагад танилцуулахаар ажиллаж байна.

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ